



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/145

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай


Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4; Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улирлын томуугийн эсрэг "Vaxigrip" вакцины хуваарийг нэгдүгээр, Вакциныг хэрэглэх зааврыг хоёрдугаар, Хамралтын мэдээний хүснэгтийг гуравдугаар, Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг тандах хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Улирлын томуугийн эсрэг вакцинаар Нийслэлийн Багануур, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн сонгогдсон цэцэрлэгийн хүүхдийг тархвар судлалын заалтаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т, дархлаажуулалтын хамралтын мэдээг нэгтгэн, 2016 оны 12 дугаар сарын 15-ны дотор тус яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт ирүүлэхийг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080533



Эрүүл мэндийн сайдын
2016 оны 11 сарын 24-ны өдрийн
А/145 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт


**ТАРХВАР СУДЛАЛЫН ЗААЛТААР ДАРХЛААЖУУЛАХ УЛИРЛЫН
ТОМУУГИЙН ЭСРЭГ ВАКЦИНЫ ХУВААРЬ**

Франц улсын Санофи Пастер үйлдвэрийн улирлын томуугийн эсрэг
идэвхгүйжүүлсэн VAXIGRIP вакцин

д/д	Цэцэрлэгийн нэр	Вакцин тоо (хүн тун)
1. Баянзүрх дүүрэг		
1.1	115-р цэцэрлэг	500
1.2	128-р цэцэрлэг	200
1.3	167-р цэцэрлэг	140
1.4	168-р цэцэрлэг	240
1.5	169-р цэцэрлэг	230
1.6	172-р цэцэрлэг	170
1.7	199-р цэцэрлэг	300
1.8	200-р цэцэрлэг	300
1.9	201-р цэцэрлэг	280
1.10	202-р цэцэрлэг	270
1.11	203-р цэцэрлэг	210
1.12	20-р цэцэрлэг	430
1.13	210-р цэцэрлэг	160
1.14	213-р цэцэрлэг	200
1.15	32-р цэцэрлэг	230
1.16	3-р цэцэрлэг	470
1.17	40-р хүүхдийн клиник сувилал	140
1.18	45-р цэцэрлэг	240
1.19	52-р цэцэрлэг	280
1.20	62-р цэцэрлэг	330
1.21	63-р цэцэрлэг	280
1.22	64-р цэцэрлэг	130
1.23	6-р цэцэрлэг	400
1.24	8-р цэцэрлэг	160
	Дэд дүн	6290
2. Сүхбаатар дүүрэг		
2.1	36-р цэцэрлэг	140
2.2	51-р цэцэрлэг	380
2.3	109-р цэцэрлэг	320
2.4	130-р цэцэрлэг	240
2.5	150-р цэцэрлэг	130

2.6	159-р цэцэрлэг	80
2.7	166-р цэцэрлэг	150
2.8	171-р цэцэрлэг	140
2.9	175-р цэцэрлэг	110
2.10	205-р цэцэрлэг	120
2.11	217-р цэцэрлэг	140
2.12	225-р цэцэрлэг	280
	Дэд дүн	2230
3. Сонгинохайрхан дүүрэг		
3.1	38-р цэцэрлэг	320
3.2	78-р цэцэрлэг	160
3.3	80-р цэцэрлэг	550
3.4	81-р цэцэрлэг	470
3.5	84-р цэцэрлэг	220
3.6	90-р цэцэрлэг	140
3.7	91-р цэцэрлэг	500
3.8	111-р цэцэрлэг	500
3.9	116-р цэцэрлэг	170
3.10	117-р цэцэрлэг	700
3.11	125-р цэцэрлэг	160
3.12	127-р цэцэрлэг	550
3.13	148-р цэцэрлэг	240
3.14	156-р цэцэрлэг	320
3.15	158-р цэцэрлэг	240
3.16	163-р цэцэрлэг	500
3.17	170-р цэцэрлэг	430
3.18	188-р цэцэрлэг	250
3.19	192-р цэцэрлэг	150
3.20	195-р цэцэрлэг	110
	Дэд дүн	6680
4. Баянгол дүүрэг		
4.1	15-р цэцэрлэг	240
4.2	30-р цэцэрлэг	150
4.3	47-р цэцэрлэг	100
4.4	57-р цэцэрлэг	260
4.5	133-р цэцэрлэг	500
4.6	141-р цэцэрлэг	480
4.7	33-р цэцэрлэг	160
	Дэд дүн	1890
5. Чингэлтэй дүүрэг		
5.1	173-р цэцэрлэг	110
5.2	224-р цэцэрлэг	170
5.3	43-р цэцэрлэг	170
5.4	31-р цэцэрлэг	300
5.5	124-р цэцэрлэг	500
5.6	56-р цэцэрлэг	360

5.7	126-р цэцэрлэг	100
5.8	83-р цэцэрлэг	500
5.9	102-р цэцэрлэг	360
5.10	103-р цэцэрлэг	440
5.11	174-р цэцэрлэг	120
5.12	155-р цэцэрлэг	230
5.13	154-р цэцэрлэг	230
	Дэд дүн	3590
6. Багануур дүүрэг		
6.1	131-р цэцэрлэг	310
6.2	132-р цэцэрлэг	176
6.3	138-р цэцэрлэг	400
6.4	139-р цэцэрлэг	308
6.5	142-р цэцэрлэг	240
6.6	193-р цэцэрлэг	360
6.7	194-р цэцэрлэг	150
6.8	235-р цэцэрлэг	80
6.9	241-р цэцэрлэг	240
6.10	Төмөр замын цэцэрлэг	56
	Дэд дүн	2320
7	Сайн дурын дархлаажуулалтад	9000
8	УИХ-ын тамгын газар	185
9	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	55
10	Эрүүл мэндийн яам	200
11	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нөөцөд	560
Нийт дүн		33000



Эрүүл мэндийн сайдын
2016 оны 11 сарын 24-ны өдрийн
А/НХ дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ФРАНЦ УЛСЫН САНОФИ ПАСТЕР ҮЙЛДВЭРИЙН УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН “VAXIGRIP” ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Найрлага:

Уг вакцин нь ДЭМБ-аас зөвлөсөн томуугийн вирусийн 3 дэд хэвшинжийг агуулсан.
Үүнд:

А/Калифорния/7/2009(H1N1)pdm09-төст омог (NYMC X-179A)15µg
гемаглютинин

А/Хонг Конг/4801/2014(H3N2)-төст омог (NYMC X- 263B)15µg
гемаглютинин

В/Brisbane/60/2008- төст омог (зэрлэг хэв шинж)..15µg
гемаглютинин

Нэмэлт бодис: Натри хлорын буфер уусмал, дисодиум фосфат дигидрат,
калийн дигидроген фосфат, кали хлорид, тарилгын шингэн.

Хэрэглээ:

Томуугийн вирусийн эсрэг дархлаа үүсгэнэ. Томуугийн өвчлөл өндөртэй бүсийн
томуу өвчинд өртөмхий хүүхэд, өндөр настан зэрэг эрсдэлт бүлгийн хүн амыг
дархлаажуулна.

Савлагаа: 0.5 мл 1 хүн тунгаар тариурт савлагдсан. Вакциныг зөөлөн сэгсэрсний
дараа цайвар цийдмэг өнгөтэй болно.

Тарих тун хэмжээ, хэрэглэх арга:

Насанд хүрэгчид: 0.5 мл-ээр 1 удаа

Хүүхэд: 3 ба түүнээс дээш настай хүүхдэд 0.5 мл-ээр 1 удаа

6 сартайгаас 3 хүртэлх (2 нас 11 сар 29 хоног) настай хүүхэд
0.25 мл-ээр 1 удаа тарина.

Вакциныг 6-9 хүртэлх сартай хүүхдэд гуяны булчингийн гадна талыг 3 хуваасны
дээд, дунд хэсгийн заагт, 9 сар ба түүнээс дээш насны хүүхэд, насанд хүрэгчдэд
гарын бугалганы дельтойд (гурван толгойт) булчинд тарина.

Эсрэг заалт:

- Вакцины найрлагад орсон бодис, өндөг, неомицин, формальдегид, октоксинол-9-д харшилтай хүмүүст хэрэглэхгүй.
- Хэрэв өндөр эсвэл дунд зэргийн халуунтай, томуугийн шинж тэмдэг илэрсэн, өвчний хурц үед, архаг өвчний сэдрэлтийн үед биеийн байдал хэвийн болтол вакцин тарихыг түр хойшлуулна.
- Хими эмчилгээ, цитотоксин, кортикостероид зэрэг дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа үед хийхгүй.

Анхааруулга:

- Вакцин хийхээс өмнө эмчийн үзлэг хийнэ. Дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа, цус шүүрэх хамшинж бүхий хүмүүс вакцинд хамрагдах эсэхийг эмч үзэж шийдвэрлэнэ.
- Анафилаксийн шокийн үед хэрэглэх адреналин болон яаралтай тусламжийн эм тариаг бэлэн байлгана.
- Вакциныг хэрэглэхийн өмнө зөөлөн хөдөлгөж, сэгсэрнэ.
- Вакцины өнгө өөрчлөгдсөн, гадны биет харагдвал хэрэглэхгүй.
- Вакциныг өөр эмийн бодистой хольж болохгүй.
- Вакцин тарихдаа судас хатгагдсан эсэхийг шалгана.
- 6 сартайгаас 3 хүртэлх насны хүүхдэд 0.25 мл-ээр тарих учир тариурт үлдэж буй 0.25 мл-ийг аюулгүй хайрцагт шууд хийж устгана.

ТАРИУРТ ҮЛДЭЖ БУЙ 0.25 МЛ-ИЙГ ДАРААГИЙН ХҮҮХДЭД ХИЙЖ БОЛОХГҮЙ!

- Сүүлийн нэг сарын дотор ямар нэгэн вакцин хийлгээгүй байх хэрэгтэй.

Бусад эмийн бодистой харилцан үйлчлэл:

- Уг вакциныг бусад вакцинтай нэг өдөр хийж болно. Гэхдээ тарих талбай нь өөр байх хэрэгтэй.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд:

Жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд вакцин хийлгэхийн өмнө эмчид үзүүлнэ. Жирэмсний аль ч хугацаанд болон хөхүүл үед уг вакциныг хийж болно.

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:

Вакцин тариулсан 10 хүн тутмын нэгд хөнгөн хэлбэрийн урвал илэрч болно.

Үүнд: Халуурах, толгой өвдөх, булчин өвдөх, тайван бус цочромтгой болох, уйлагнах, ядарч сульдах, унтаарах, суулгах, хоолонд дургүй болох, бөөлжих, чичрэх, тарьсан хэсэгт өвдөх, улайх, хавдах, хатуурах, загатнах гэх мэт.

Вакцин тариулсан 100 хүн тутмын нэгд ханиалгах, толгой эргэх, хүзүүний эсвэл цавь суганы булчирхай томрох, цус шүүрэх шинж тэмдэг илэрч болно.

Вакцин тариулсан 1000 хүн тутмын нэгд захын мэдрэлийн үрэвсэл (парастезия), мэдрэг чанар буурах (гипостезия), гар өвдөх, сулрах (бугалганы радикулит), мэдрэлийн өвдөлт (невралгия) зэрэг шинж тэмдэг илэрч болно.

Маш ховор тохиолдолд хүнд хэлбэрийн дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрч болно.

Харшлын урвал: Дараах тохиолдолд яаралтай эмчид хандана.

1. Хүнд хэлбэрийн харшлын урвалууд: Цусны даралт буурах, амьсгалын тоо олшрох, зүрхний цохилт олшрох, судасны лугшилт сулрах, чичрүүдэс хүрэх, толгой эргэх, коллапс, анафилаксийн шок, анафилактик хариу урвал илэрч болно.
2. Хэсэг газрын харшлын урвал: Харшлын тууралт гарах, загатнах, чонон хөрвөс, улайлт, эритема илэрч болно. Эдгээр шинжүүд 3-8 настай хүүхдийн

дунд ховор тохиолдоно, 1000 хүн тутамд нэг тохиолдол, чонон хөрвөс 100 хүн тутамд нэг тохиолдож болно.

Хадгалалт:

- Хүүхдээс хол байлгана.
- Хэрэглэх хугацаа дууссан бол хэрэглэхгүй. Хугацаа нь тухайн сарын сүүлийн өдөр хүртэл байна.
- Хөргөгчид 2-8 хэмд хадгална. Хөлдөөж болохгүй.

Үйлдвэрлэгч: Sanofi Pasteur SA, France

Эрүүл мэнд
2016 оны 11 сар
45 дугаар тушаалын 3 дугаар тусламжийн үйлчилгээний үнэ

Дүүрэг:..... Цэцэрлэгийн нэр:..... Огноо:.....

Дархлаажуулах ажлыг зохион байгуулсан ӨЭМТ-ийн нэр _____

Эмчийн нэр: _____
Вакцинатор сувилагчийн нэр: _____

[illegible]

Тайлбар: Тархвар судлалын заалтаар сонгогдсон хүүхдийн цэцэрлэгт хийнэ

Мэдээ гаргасан.....

Мэдээ хянасан.....

Эрүүл мэндийн
2016 оны ... сарыг
... дугаар тушаалын 4 дүгээр

Цэцэрлэгийн нэр: _____ Бүлэг: _____
Холбоо барих утасны дугаар: _____

Дархлаажуулалт хийсэн огноо: _____ / _____ / _____
Дархлаажуулсан хүүхдийн тоо: _____

Мэдээ гаргасан.....

Мэдээ хянасан.....